



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН  
ДАРГА ГОМБОЖАВЫН  
ЗАНДАНШАТАР ТАНАА

**МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР**

Төрийн ордон, Жанжин Д.Сүхбаатарын талбай,  
6 дугаар хороо, Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар хот, 14201  
Утас: (976-51) 26 08 17, Факс: (976-51) 26 24 08,  
Цахим шуудан: info@cabinet.gov.mn,  
Цахим хуудас: www.mongolia.gov.mn

дс.06.23 № ЗГ-1/104  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

Хуулийн төсөл өргөн  
мэдүүлэх тухай

Хуулийн давхардал, хийдэл, зөрчлийг арилгах зорилгоор боловсруулсан Үндэсний их баяр наадмын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Хөдөлмөрийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцэн шийдвэрлэсний дагуу Улсын Их Хуралд өргөн мэдүүлж байна.

Улсын Их Хурлын чуулганы хуралдаанаар хэлэлцүүлж өгөхийг хүсье.



МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД

Д.ӨЮУН-ЭРДЭНЭ

000234002889



**МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН  
ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР**

Төрийн ордон, Жанжин Д.Сүхбаатарын талбай,  
6 дугаар хороо, Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар хот, 14201  
Утас: (976-51) 26 08 17, Факс: (976-51) 26 24 08,  
Цахим шуудан: info@cabinet.gov.mn,  
Цахим хуудас: www.cabinet.gov.mn

ддб. дб.дб № хбг / 15д9  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

**Хуулийн төсөл өргөн мэдүүлэх  
хугацааг товлох тухай**

Хуулийн давхардал, хийдэл, зөрчлийг арилгах зорилгоор боловсруулсан Үндэсний их баяр наадмын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Хөдөлмөрийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцээд Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхээр шийдвэрлэсний дагуу холбогдох материалын хамт хүргүүлж байна.

Хянан үзэж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх хугацааг товлож өгөхийг хүсье.

Хавсралт <sup>дд</sup> хуудастай.

МОНГОЛ УЛСЫН САЙД,  
ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ  
ЭРХЛЭХ ГАЗРЫН ДАРГА

Д.АМАРБАЯСГАЛАН

000235016589

# МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛЭЭС

Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 06 дугаар сарын 21-ний өдрийн хуралдааны 27 дугаар тэмдэглэлд:

“ХХ.ХЭЛЭЛЦСЭН нь: Үндэсний их баяр наадмын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Хөдөлмөрийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл

ШИЙДВЭРЛЭСЭН нь: Хуулийн давхардал, хийдэл, зөрчлийг арилгах зорилгоор боловсруулсан Үндэсний их баяр наадмын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Хөдөлмөрийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хэлэлцээд хуралдаан дээр Засгийн газрын гишүүдээс гаргасан саналыг тусган Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхээр тогтов.” гэжээ.



ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР



**МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ ЗҮЙ,  
ДОТООД ХЭРГИЙН САЙД**

Засгийн газрын V байр, Б.Ширэндэвийн гудамж 8/4,  
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160  
Утас/Факс: (976-51) 26 75 33,  
Цахим шуудан: info@mojha.gov.mn,  
Цахим хуудас: www.mojha.gov.mn

2023. 06.19 № 1/3480

танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

「 МОНГОЛ УЛСЫН САЙД, ЗАСГИЙН  
ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗРЫН  
ДАРГА Д.АМАРБАЯСГАЛАН ТАНАА

Хууль тогтоомжийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.8 дахь хэсэгт заасны дагуу Хуулийн давхардал, хийдэл, зөрчлийг арилгах зорилгоор боловсруулсан Үндэсний их баяр наадмын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Хөдөлмөрийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх нь зүйтэй гэж үзэв.



Х.НЯМБААТАР

151603189

A5 Файл.2023



**МОНГОЛ УЛСЫН САНГИЙН САЙД**

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,  
С.Данзангийн гудамж 5/1, Засгийн газрын II байр,  
Утас/факс: (976-51) 26 74 68, И-мэйл: info@mof.gov.mn  
Вэбсайт: www.mof.gov.mn

2023.06.22 № 01/4659  
танай 2023.06.20 ны № 1/3463 -т

**ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД ХЭРГИЙН  
САЙД Х.НЯМБААТАР ТАНАА**

Таны ирүүлсэн Үндэсний их баяр наадмын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Хөдөлмөрийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг Хууль тогтоомжийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.7 дахь хэсэгт заасны дагуу Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх зөвшөөрлийг олгож байна.

Хүндэтгэсэн,

**Б.ЖАВХЛАН**

**9761001403**



С.АМАРСАЙХАН



Х.НЯМБААТАР

**ХУУЛИЙН ДАВХАРДАЛ, ХИЙДЭЛ, ЗӨРЧЛИЙГ АРИЛГАХ ЗОРИЛГООР  
БОЛОВСРУУЛАХ ҮНДЭСНИЙ ИХ БАЯР НААДМЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ,  
ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ, ХӨДӨЛМӨРИЙН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ  
ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ**

**Нэг.Хуулийн төсөл боловсруулах үндэслэл, шаардлага**

**1.1.Хууль зүйн үндэслэл.**

Монгол Улсын Үндсэн хуулийн<sup>1</sup> нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсэгт “Монгол Улс бол тусгаар тогтносон, бүрэн эрхт, Бүгд найрамдах улс мөн.” гэж заасан. Энэ утгаараа Үндэсний их баяр наадам нь Монгол Улсын тусгаар тогтнол, бүрэн эрхт байдлын бэлгэдэл төдийгүй уламжлалт урлаг, спорт, биет бус өв бөгөөд эх оронч үзэл санаа дэлгэрэн хөгжихөд чухал ач холбогдолтой юм.

Монгол Улсын хууль тогтоомжийг 2024 онд хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэлд<sup>2</sup> Монголын үндэсний бөх, сурын харваачаас авах допингийн шинжилгээ, давтан шинжилгээ, допингийн хариуг нийтэд мэдээлэх, үүнтэй холбоотой гарсан гомдол, маргааныг шийдвэрлэх зохицуулалтыг олон улсын дүрэм, журамд нийцүүлэн боловсронгуй болгох, сэргээш хэрэглэсэн тохиолдолд оногдуулах хариуцлагын тогтолцоог бий болгох, Үндэсний баяр наадмын шагайн харвааг зохион байгуулах, чимэг цол олгохтой холбоотой зохицуулалт болон Үндэсний их баяр наадмыг зохион байгуулах хорооны чиг үүргийг нарийвчлан зохицуулах зорилтыг дэвшүүлсэн.

Түүнчлэн 2010 оны 10 дугаар сард НҮБ-ын Боловсрол, соёл, шинжлэх ухааны байгууллага (Юнеско)-ын “Хүн төрөлхтний соёлын биет бус өвийн жагсаалт”-д монгол наадмыг бүртгэсэн бөгөөд эрийн гурван наадам (бөх, хурдан морины уралдаан, сурын харваа багтана) нь Монголын эртний уламжлалт баяр наадмын зан үйл гэж тодорхойлж өгсөн. Уг жагсаалтад бүртгүүлснээр монгол наадам нь Монголын соёлын өв болохын хувьд уламжлалт байдлаар цаашид хадгалж үлдээх үүргийг манай улс хүлээх болсон.

Үндэсний их баяр наадмын тухай хууль<sup>3</sup> /шинэчилсэн найруулга/ нь 2022 оны 06 дугаар сарын 28-ны өдөр батлагдан мөрдөж байна.

<sup>1</sup> Монгол Улсын Үндсэн хууль “Төрийн мэдээлэл” эмхтгэлийн 1992 оны 1 дугаарт нийтлэгдсэн,

<sup>2</sup> Монгол Улсын Их Хурлын 2021 оны 12 дугаар тогтоол, “Төрийн мэдээлэл” эмхтгэлийн 2021 оны 11 дүгээрт нийтлэгдсэн,

<sup>3</sup> Үндэсний их баяр наадмын тухай хууль “Төрийн мэдээлэл” эмхтгэлийн 2022 оны 25 дугаарт нийтлэгдсэн.

Уг хуулийн шинэчилсэн найруулгаар Монгол Улсад хүчин төгөлдөр мөрдөж байгаа хууль тогтоомжийн нэр томъёотой нийцүүлж, хууль хоорондын болон хуулийн зүйл, хэсэг, заалт хоорондын зөрчил, хийдлийг арилгаж, уялдаа холбоог хангах, Үндэсний их баяр наадмын үйл ажиллагаанд оролцогчдын эрх, үүргийг тодорхой болгож, хариуцлагын механизмыг боловсронгуй болгохоор тусгасан, тухайлбал, допинг хэрэглэсэн бөх, сурын харваач, допинг хэрэглэхийг зөвлөсөн, шаардсан дасгалжуулагч, эмч, дэвжээнд олон улсын допингийн дүрмийн дагуу хариуцлага оногдуулах механизмыг бүрдүүлэх, Үндэсний их баяр наадмыг зохион байгуулахтай холбоотой нарийвчилсан зохицуулалтыг бий болгосон гэх зэрэг олон асуудлыг зохицуулан холбогдох харилцааг зохицуулсан эрх зүйн орчныг боловсронгуй болгосон.

Гэвч Үндэсний их баяр наадмын тухай хуулийн зарим зохицуулалт нь бусад хуулийн зохицуулалттай зөрчилдөж, хуулийг нэг мөр хэрэглэхэд хүндрэлтэй байдлыг үүсгэж байна.

Тодруулбал, Үндэсний их баяр наадмын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.2-т "Хуульд өөрөөр заагаагүй бол Үндэсний их баяр наадмыг жил бүр Нийтээр тэмдэглэх баярын болон тэмдэглэлт өдрүүдийн тухай хуулийн 4.1.1-д заасны дагуу аймаг, сумын баяр наадмыг 07 дугаар сарын 10, 11-ний өдрүүдэд, улсын баяр наадмыг 07 дугаар сарын 11, 12, 13-ны өдрүүдэд улс орон даяар нэгэн зэрэг тэмдэглэнэ." гэж, Нийтээр тэмдэглэх баярын болон тэмдэглэлт өдрүүдийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1-д "Хуульд өөрөөр заагаагүй бол Үндэсний их баяр наадам, Ардын хувьсгалын ойн баяр: 7 дугаар сарын 10, 11, 12, 13, 14, 15;" гэж нийтээр тэмдэглэх буюу нийтээр амрах өдрүүдийг тус тус заасан болно. Өөрөөр хэлбэл, 7 дугаар сарын 10, 11, 12, 13, 14, 15-ны өдрүүд нь нийтээр тэмдэглэх баярын өдөрт хамаарах бөгөөд тухайн өдрүүдэд бүх нийтээр амрахаар заасан.

Харин Хөдөлмөрийн тухай хуулийн 97 дугаар зүйлийн 97.1.6-д "Үндэсний их баяр наадам, Ардын хувьсгалын ойн баяр: долдугаар сарын 11, 12, 13, 14, 15;" гэж заасан нь зөрчил үүсгэх бөгөөд хуулийг нэг мөр хэрэгжүүлэхэд хүндрэлтэй байдлыг бий болгож байна.

Тодруулбал, Нийтээр тэмдэглэх баярын болон тэмдэглэлт өдрүүдийн тухай хуулийн 4.1.1-д "Хуульд өөрөөр заагаагүй бол" гэсэн зохицуулалт нь Үндэсний их баяр наадмын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.2, 5.3 дахь хэсгийн "онцгой нөхцөл байдлаас" гэсэн нэр томъёотой холбоотой бөгөөд тухайн нөхцөл байдалд Үндэсний их баяр наадмын өдрүүдийг Нийтээр тэмдэглэх баярын болон тэмдэглэлт өдрүүдийн тухай хуулийн 4.1.1-д зааснаас өөр өдрүүдэд Засгийн газрын шийдвэрээр шилжүүлж болох зохицуулалттай болно.

Гэвч энэхүү зохицуулалтын "Хуульд өөрөөр заагаагүй бол" гэсэн нэр томъёо нь Хөдөлмөрийн тухай хуулийн 97 дугаар зүйлийн 97.1.6 дахь заалтад "Үндэсний их баяр наадам, Ардын хувьсгалын ойн баяр: долдугаар сарын 11, 12, 13, 14, 15;" гэж заасантай холбогдоход хүрээд байна.

Түүнчлэн Үндэсний их баяр наадмын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.3 дахь хэсэгт Улсын баяр наадамд амжилт үзүүлсэн бөхөд цол олгох зохицуулалтыг заасан боловч зарим цол олгох зохицуулалтыг орхигдуулсан нь хуулийг хэрэглэхэд хүндрэлтэй байдлыг үүсгэхээр байна. Тухайлбал, Улсын арслан цолтой бөх ес даван түрүүлсэн тохиолдолд аварга цол олгох болон Улсын аварга цолтой бөх ес даван түрүүлбэл улсын даян аварга цол олгох зохицуулалт тус тус орхигдсон байна.

Дээрх тохиолдолд цол олгохдоо Үндэсний их баяр наадмын тухай хуулийн ямар зохицуулалтыг үндэслэн цол олгох нь тодорхойгүй болох үр дагавартай болно.

Сүүлийн жилүүдэд улсын баяр наадамд түрүүлсэн, амжилттай сайн барилдаж цол, чимэг авсан бөх допинг хэрэглэсэн нь шинжилгээгээр тогтоогдож, цол, чимгээ хураалгах, хэрэглэсэн, хэрэглээгүй дээр маргалдах, шүүхээр шийдвэрлүүлэх тохиолдолд ихээхэн гарсаар байна. Үндэсний их баяр наадмын тухай хуульд допинг хэрэглэхийг хориглох, хэрэглэсэн тохиолдолд хүлээлгэх хариуцлагын механизмыг суулгаж өгсөн боловч энэ нь зөвхөн Улсын баяр наадамд дөрөв, түүнээс дээш давсан бөхөд хамааралтай байхаар зохицуулалтыг заасан болно.

Харин аймгийн баяр наадамд түрүүлсэн, шөвгөрсөн бөхөөс допингийн шинжилгээ авах зохицуулалт байхгүй байна. Аймгийн баяр наадам нь аймгийн цол авах, цаашлаад улсын цол авахад өндөр ач холбогдолтой баяр юм.

Түүнчлэн Үндэсний их баяр наадмын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.5-д аймгийн баяр наадмын үндэсний бөхийн барилдаанд 128 бөх барилдахаар заасан нь тухайн аймгийн тэгш ойн баяр наадамд 128-аас дээш тооны бөх барилдах боломжийг тоогоор хязгаарлахаар байна. Тухайлбал, бөх олонтой аймгийн тэгш ойн баяр наадамд Улсын аварга цолтноос эхлэн эрэмбэлэхэд аймгийн арслан цолтой бөхөөр бүртгэл хаагдаж, аймаг, сумын цолтой бөх, залуу бөх бүртгүүлэх, барилдах нөхцөл хаагдахад хүрч байна.

Үндэсний их баяр наадам нь 1921-1925 оныг хүртэлх хугацаанд “Цэргийн наадам” гэж нэрлэгдэн цэргийн хүрээнд тэмдэглэж ирсэн бөгөөд 1925 оноос хойш “Үндэсний их баяр наадам”, “Улс хувьсгалын баяр наадам”, “Ардын хувьсгалын баяр наадам” зэргээр нэрлэгдэн Монгол Улс даяар тэмдэглэн ирсэн байдаг.

Түүнчлэн, цэргийн “Хар сүлд” цэнгүүлэх ёслолыг хийж, баяр наадмыг зохион байгуулж ирсэн уламжлалтай. Бүх цэргийн наадамд 1961 оноос эхлэн түрүүлсэн бөхөд “Цэргийн арслан”, үзүүрлэсэн бөхөд “Цэргийн заан” цолыг олгож ирсэн бөгөөд энэхүү цол олгох асуудал нь зохицуулалтгүй хэвээр байна. Тодруулбал, цэргийн баяр наадамд түрүүлсэн бөхөд “Цэргийн арслан” гэдэг цолыг аймгийн цолтой адилтган олгож байгаа боловч уг цолыг олгох зохицуулалт байхгүй, хууль зүйн хувьд үр дагавар үүсгэхгүй.

Дээрх хууль зүйн болон практик үндэслэл, шаардлагад үндэслэн Үндэсний их баяр наадмын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Хөдөлмөрийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг тус тус боловсруулна.

### **Хоёр.Хуулийн төслийн зорилго, ерөнхий бүтэц, зохицуулах харилцаа, хамрах хүрээ**

Хууль тогтоомжийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2 дахь хэсгийн дагуу хуулийн төслийг хуулийн давхардал хийдэл, зөрчлийг арилгах зорилгоор хэд хэдэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хэлбэрээр боловсруулна.

Үндэсний их баяр наадмын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон Хөдөлмөрийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд уг хуулиар зохицуулах харилцаа, хамрах хүрээг дараах байдлаар тусгана:



-Аймгийн тэгш он баяр наадамд 256 бөх барилдаж болох зохицуулалтыг тусгана;

-Улсын баяр наадамд амжилт гаргасан бөхөд олгох цолыг тодорхой болгох зохицуулалтыг нарийвчлан тусгана;

-Улсын баяр наадамд түрүүлсэн, үзүүрлэсэн, шөвгөрсөн бөхчүүдийн эрэмбийг Монголын үндэсний бөхийн холбооны дүрмээр зохицуулах нарийвчилсан зохицуулалтыг тусгана;

-Аймгийн баяр наадамд үзүүрлэсэн, шөвгөрсөн бөхөөс допингийн шинжилгээ авах зохицуулалтыг тусгаж, хариуцлагын механизмыг Улсын баяр наадамтай адилтган үзэх эрх зүйн орчныг бүрдүүлнэ;

-Монгол Улсад уламжлан ирсэн цэргийн наадамд цол олгох эрх зүйн орчныг аймгийн баяр наадамд цол олгохтой адилтган бүрдүүлнэ;

-Үндэсний их баяр наадмын тухай хууль, Нийтээр тэмдэглэх баярын болон тэмдэглэлт өдрүүдийн тухай хууль хоорондын зөрлийг арилгах, хуулийг нэг мөр хэрэглэх эрх зүйн орчныг бүрдүүлнэ.

**Гурав.Хуулийн төсөл батлагдсаны дараа үүсч болох нийгэм, эдийн засаг, хууль зүйн үр дагавар, тэдгээрийг шийдвэрлэх талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээний санал**

Хуулийн төсөл батлагдсанаар хуулийн хэрэгжилт, үр нөлөө сайжирч, дараах эерэг үр дүн гарна гэж тооцоолж байна.

-Үндэсний их баяр наадмыг зохион байгуулах эрх зүйн орчин боловсронгуй болно;

-Үндэсний их баяр наадмаар барилдах бөхөөс гадна аймгийн баяр наадамд барилдан түрүүлсэн, үзүүрлэсэн бөхөөс тамирчны нэгэн адил допингийн шинжилгээ авах эрх зүйн орчин бүрдэж, хариуцлагын механизм тодорхой болно;

-Хууль хоорондын уялдаа холбоо сайжирч, нэг мөр хэрэглэх боломж бүрдэнэ.

Хуулийн төсөл батлагдсанаар хуулийг хэрэгжүүлэхтэй холбоотой зардлыг улсын төсвөөс нэмж санхүүжүүлэх шаардлагатай.

**Дөрөв.Хуулийн төсөл нь Монгол Улсын Үндсэн хууль болон бусад хуультай хэрхэн уялдах, хуулийг хэрэгжүүлэхэд шинээр боловсруулах, хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн талаар**

Хуулийн төсөл нь Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээ, конвенц болон бусад хууль тогтоомжтой нийцсэн байна.

Хуулийн төсөлтэй холбоотойгоор өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл байхгүй болно.

---o0o---

## ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

### **Хуулийн давхардал, хийдэл, зөрчлийг арилгах зорилгоор боловсруулсан Үндэсний их баяр наадмын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Хөдөлмөрийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар**

Хууль тогтоомжийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2 дахь хэсэгт заасны дагуу хуулийн давхардал, хийдэл, зөрчлийг арилгах зорилгоор Үндэсний их баяр наадмын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Хөдөлмөрийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хуулийн давхардал хийдэл, зөрчлийг арилгах зорилгоор хэд хэдэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хэлбэрээр боловсрууллаа.

Үндэсний их баяр наадмын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон Хөдөлмөрийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд Аймгийн баяр наадмын тэгш ойд 256 бөх барилдаж болох зохицуулалт, Улсын баяр наадамд амжилт гаргасан бөхөд олгох цолыг тодорхой болгох зохицуулалт, Улсын баяр наадамд түрүүлж, үзүүрлэж, шөвгөрсөн бөхчүүдийн эрэмбийг Монголын үндэсний бөхийн холбооны дүрмээр зохицуулах нарийвчилсан зохицуулалт, аймгийн баяр наадамд үзүүрлэсэн, шөвгөрсөн бөхөөс допингийн шинжилгээ авах зохицуулалтыг тусгаж, хариуцлагын механизмыг Улсын баяр наадамтай адилтган үзэх зохицуулалт, Үндэсний их баяр наадмын тухай хууль, Нийтээр тэмдэглэх баярын болон тэмдэглэлт өдрүүдийн тухай хууль хоорондын зөрлийг арилгах, хуулийг нэг мөр хэрэглэх эрх зүйн орчныг бий болгох зохицуулалтыг тус тус тусгасан.

Хуулийн төсөлд зарчмын шинжтэй дараах өөрчлөлтийг тусгасан болно. Үүнд:

1.Сүүлийн жилүүдэд улсын баяр наадамд түрүүлсэн, амжилттай сайн барилдаж цол, чимэг авсан бөх допинг хэрэглэсэн нь шинжилгээгээр тогтоогдож, цол, чимгээ хураалгах, хэрэглэсэн, хэрэглээгүй дээр маргалдах, шүүхээр шийдвэрлүүлэх тохиолдолд ихээхэн гарсаар байна. Үндэсний их баяр наадмын тухай хуульд допинг хэрэглэхийг хориглох, хэрэглэсэн тохиолдолд хүлээлгэх хариуцлагын механизмыг суулгаж өгсөн боловч энэ нь зөвхөн Улсын баяр наадамд дөрөв, түүнээс дээш давсан бөхөд хамааралтай байхаар зохицуулалтыг заасан болно.

Харин аймгийн баяр наадам, түүнтэй адилтгах баяр наадамд түрүүлсэн, шөвгөрсөн бөхөөс допингийн шинжилгээ аймгийн цол авах, цаашлаад улсын цол авахад өндөр ач холбогдолтой баяр тул Үндэсний их баяр наадмын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2 дахь хэсэгт Улсын баяр наадамд дөрөв, түүнээс дээш давсан бөх, үндэсний сурын харвааны эрэгтэй болон эмэгтэй тус бүр эхний найман байр эзэлсэн харваачаас допингийн шинжилгээ авахаар заасныг өргөжүүлэн аймгийн баяр наадамд 128 болон 256 бөх барилдсан үл хамааран шөвгийн дөрөвт үлдсэн бөхөөс тамирчны нэгэн адил допингийн шинжилгээг авах зохицуулалтыг тусгасан. Мөн уг зохицуулалтын хэрэгжүүлэхэд төсөв, зохион байгуулалтын ажил шаардлагатайг харгалзан аймгийн баяр наадмаас допингийн шинжилгээг авч эхлэх хугацааг 2 жилийн дараагаас буюу уг зохицуулалтыг 2025 оноос хэрэгжиж эхлэхээр хуулийн төсөлд шилжилтийн үеийн зохицуулалтыг тусгасан.

Дээрх зарчмын шинжтэй өөрчлөлтөөс гадна хууль хоорондын уялдаа холбоог сайжруулах, зөрчил, хийдлийг арилгах хүрээнд дараах өөрчлөлтийн тусгасан болно. Үүнд:

1. Үндэсний их баяр наадмын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.2-т "Хуульд өөрөөр заагаагүй бол Үндэсний их баяр наадмыг жил бүр Нийтээр тэмдэглэх баярын болон тэмдэглэлт өдрүүдийн тухай хуулийн 4.1.1-д заасны дагуу аймаг, сумын баяр наадмыг 07 дугаар сарын 10, 11-ний өдрүүдэд, улсын баяр наадмыг 07 дугаар сарын 11, 12, 13-ны өдрүүдэд улс орон даяар нэгэн зэрэг тэмдэглэнэ." гэж, Нийтээр тэмдэглэх баярын болон тэмдэглэлт өдрүүдийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1-д "Хуульд өөрөөр заагаагүй бол Үндэсний их баяр наадам, Ардын хувьсгалын ойн баяр: 7 дугаар сарын 10, 11, 12, 13, 14, 15;" гэж нийтээр тэмдэглэх буюу нийтээр амрах өдрүүдийг тус тус заасан болно. Өөрөөр хэлбэл, 7 дугаар сарын 10, 11, 12, 13, 14, 15-ны өдрүүд нь нийтээр тэмдэглэх баярын өдөрт хамаарах бөгөөд тухайн өдрүүдэд бүх нийтээр амрахаар заасан.

Харин Хөдөлмөрийн тухай хуулийн 97 дугаар зүйлийн 97.1.6-д "Үндэсний их баяр наадам, Ардын хувьсгалын ойн баяр: долдугаар сарын 11, 12, 13, 14, 15;" гэж заасан нь зөрчил үүсгэх бөгөөд хуулийг нэг мөр хэрэгжүүлэхэд хүндрэлтэй байдлыг бий болгож байна.

Иймд Үндэсний их баяр наадмын тухай хууль, Нийтээр тэмдэглэх баярын болон тэмдэглэлт өдрүүдийн тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль хоорондын уялдаа холбоог хангах, зөрчлийг арилгах, хуулийг нэг мөр хэрэглэх үүднээс Хөдөлмөрийн тухай хуулийн 97 дугаар зүйлийн 97.1.6 дахь заалтыг Нийтээр тэмдэглэх баярын болон тэмдэглэлт өдрүүдийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1 дэх заалттай нийцүүлэн Хөдөлмөрийн тухай хуульд 7 дугаар сарын 10-ны өдрийг нэмэх өөрчлөлтийг тусгасан.

2. Үндэсний их баяр наадмын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.3 дахь хэсэгт Улсын баяр наадамд амжилт үзүүлсэн бөхөд цол олгох зохицуулалтыг заасан боловч зарим цол олгох зохицуулалтыг орхигдуулсан нь хуулийг хэрэглэхэд хүндрэлтэй байдлыг үүсгэхээр байна. Тухайлбал, Улсын арслан цолтой бөх ес даван түрүүлсэн тохиолдолд аварга цол олгох болон Улсын аварга цолтой бөх ес даван түрүүлбэл улсын даян аварга цол олгох зохицуулалтыг тус тус орхигдсон байна. Дээрх тохиолдолд цол олгохдоо Үндэсний их баяр наадмын тухай хуулийн ямар зохицуулалтыг үндэслэн цол олгох нь тодорхойгүй болох үр дагавартай болно.

Иймд Үндэсний их баяр наадмын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 1 дүгээр зүйлд Үндэсний их баяр наадмын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.3 дахь хэсэгт "9.3.6.улсын арслан цолтой бөх ес даван түрүүлбэл улсын аварга, 9.3.7.улсын аварга цолтой бөх ес даван түрүүлбэл улсын даян аварга;" гэсэн шинэ заалтыг нэмэхээр тусгасан.

3. Үндэсний их баяр наадам нь 1921-1925 оныг хүртэлх хугацаанд "Цэргийн наадам" гэж нэрлэгдэн цэргийн хүрээнд тэмдэглэж ирсэн бөгөөд 1925 оноос хойш "Үндэсний их баяр наадам", "Улс хувьсгалын баяр наадам", "Ардын хувьсгалын баяр наадам" зэргээр нэрлэгдэн Монгол Улс даяар тэмдэглэн ирсэн байдаг.

Түүнчлэн, цэргийн "Хар сүлд" цэнгүүлэх ёслолыг хийж, баяр наадмыг зохион байгуулж ирсэн уламжлалтай. Бүх цэргийн наадамд 1961 оноос эхлэн түрүүлсэн бөхөд "Цэргийн арслан", үзүүрлэсэн бөхөд "Цэргийн заан" цолыг олгож ирсэн бөгөөд

энэхүү цол олгох асуудал нь зохицуулалтгүй хэвээр байна. Тодруулбал, цэргийн баяр наадамд түрүүлсэн бөхөд “Цэргийн арслан” гэдэг цолыг аймгийн цолтой адилтган олгож байгаа боловч уг цолыг олгох зохицуулалт байхгүй, хууль зүйн хувьд үр дагавар үүсгэхгүй юм.

Иймд Үндэсний их баяр наадмын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 1 дүгээр зүйлд Үндэсний их баяр наадмын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.9 дэх хэсэгт “Бүх цэргийн баяр наадмыг жилд нэг удаа Засгийн газрын шийдвэрээр 256 хүртэлх бөх барилдуулахаар зохион байгуулж болно. Бүх цэргийн баяр наадамд олгох цолыг аймгийн баяр наадамтай адилтган тав давсан бөхөд цэргийн начин, зургаа давсан бөхөд цэргийн харцага, үзүүрлэсэн бөхөд цэргийн заан, түрүүлсэн бөхөд цэргийн арслан цолыг батлан хамгаалах асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн олгоно.” гэж тусгасан.

Хуулийн төсөл батлагдсанаар хуулийн хэрэгжилт, үр нөлөө сайжирч, дараах эерэг үр дүн гарна гэж тооцоолж байна.Үүнд:

-Үндэсний их баяр наадмыг зохион байгуулах эрх зүйн орчин боловсронгуй болно;

-Үндэсний их баяр наадмаар барилдах бөхөөс гадна аймгийн баяр наадамд барилдан түрүүлсэн, үзүүрлэсэн бөхөөс тамирчны нэгэн адил допингийн шинжилгээ авах эрх зүйн орчин бүрдэж, хариуцлагын механизм тодорхой болно;

-Хууль хоорондын уялдаа холбоо сайжирч, нэг мөр хэрэглэх боломж бүрдэх ач холбогдолтой болно.

----o0o----

## ДЭЛГЭРЭНГҮЙ ТАНИЛЦУУЛГА

**Хуулийн давхардал, хийдэл, зөрчлийг арилгах зорилгоор боловсруулсан Үндэсний их баяр наадмын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Хөдөлмөрийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар**

Монгол Улсын Үндсэн хуулийн<sup>1</sup> нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсэгт “Монгол Улс бол тусгаар тогтносон, бүрэн эрхт, Бүгд найрамдах улс мөн.” гэж заасан. Энэ утгаараа Үндэсний их баяр наадам нь Монгол Улсын тусгаар тогтнол, бүрэн эрхт байдлын бэлгэдэл төдийгүй уламжлалт урлаг, спорт, биет бус өв бөгөөд эх оронч үзэл санаа дэлгэрэн хөгжихөд чухал ач холбогдолтой юм.

Монгол Улсын хууль тогтоомжийг 2024 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэлд<sup>2</sup> Монголын үндэсний бөх, сурын харваачаас авах допингийн шинжилгээ, давтан шинжилгээ, допингийн хариуг нийтэд мэдээлэх, үүнтэй холбоотой гарсан гомдол, маргааныг шийдвэрлэх зохицуулалтыг олон улсын дүрэм, журамд нийцүүлэн боловсронгуй болгох, сэргээш хэрэглэсэн тохиолдолд оногдуулах хариуцлагын тогтолцоог бий болгох, Үндэсний баяр наадмын шагайн харвааг зохион байгуулах, чимэг цол олгохтой холбоотой зохицуулалт болон Үндэсний их баяр наадмыг зохион байгуулах хорооны чиг үүргийг нарийвчлан зохицуулах зорилтыг дэвшүүлсэн.

Түүнчлэн, 2010 оны 10 дугаар сард НҮБ-ын Боловсрол, соёл, шинжлэх ухааны байгууллага (Юнеско)-ын “Хүн төрөлхтний соёлын биет бус өвийн жагсаалт”-д монгол наадмыг бүртгэсэн бөгөөд эрийн гурван наадам (бөх, хурдан морины уралдаан, сурын харваа багтана) нь Монголын эртний уламжлалт баяр наадмын зан үйл гэж тодорхойлж өгсөн. Уг жагсаалтад бүртгүүлснээр монгол наадам нь Монголын соёлын өв болохын хувьд уламжлалт байдлаар цаашид хадгалж үлдээх үүргийг манай улс хүлээх болсон.

Хууль тогтоомжийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2 дахь хэсэгт заасны дагуу хуулийн давхардал, хийдэл, зөрчлийг арилгах зорилгоор Үндэсний их баяр наадмын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Хөдөлмөрийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хуулийн давхардал хийдэл, зөрчлийг арилгах зорилгоор хэд хэдэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хэлбэрээр боловсрууллаа.

Үндэсний их баяр наадмын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон Хөдөлмөрийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд Аймгийн баяр наадмын тэгш ойд 256 бөх барилдаж болох зохицуулалт, Улсын баяр наадамд амжилт гаргасан бөхөд олгох цолыг тодорхой болгох зохицуулалт, Улсын баяр наадамд түрүүлж, үзүүрлэж, шөвгөрсөн бөхчүүдийн эрэмбийг Монголын үндэсний бөхийн холбооны дүрмээр зохицуулах нарийвчилсан зохицуулалт, аймгийн баяр наадамд үзүүрлэсэн, шөвгөрсөн бөхөөс допингийн шинжилгээ авах зохицуулалтыг тусгаж, хариуцлагын механизмыг Улсын баяр наадамтай адилтган үзэх зохицуулалт, Үндэсний их баяр наадмын тухай хууль, Нийтээр тэмдэглэх баярын болон тэмдэглэлт өдрүүдийн тухай хууль хоорондын зөрчлийг арилгах, хуулийг нэг мөр хэрэглэх эрх зүйн орчныг бий болгох зохицуулалтыг тус тус тусгасан.

<sup>1</sup> Монгол Улсын Үндсэн хууль “Төрийн мэдээлэл” эмхтгэлийн 1992 оны 1 дугаарт нийтлэгдсэн,

<sup>2</sup> Монгол Улсын Их Хурлын 2021 оны 12 дугаар тогтоол, “Төрийн мэдээлэл” эмхтгэлийн 2021 оны 11 дүгээрт нийтлэгдсэн,

## Хуулийн төсөлд тусгасан үндэслэл, шаардлагын тухайд:

1.Үндэсний их баяр наадмын тухай хууль<sup>3</sup> /шинэчилсэн найруулга/ нь 2022 оны 06 дугаар сарын 28-ны өдөр батлагдан мөрдөж байна. Уг хуулийн шинэчилсэн найруулгаар Монгол Улсад хүчин төгөлдөр мөрдөж байгаа хууль тогтоомжийн нэр томъёотой нийцүүлж, хууль хоорондын болон хуулийн зүйл, хэсэг, заалт хоорондын зөрчил, хийдлийг арилгаж, уялдаа холбоог хангах, Үндэсний их баяр наадмын үйл ажиллагаанд оролцогчдын эрх, үүргийг тодорхой болгож, хариуцлагын механизмыг боловсронгуй болгохоор тусгасан, тухайлбал, допинг хэрэглэсэн бөх, сурын харваач, допинг хэрэглэхийг зөвлөсөн, шаардсан дасгалжуулагч, эмч, дэвжээнд олон улсын допингийн дүрмийн дагуу хариуцлага оногдуулах механизмыг бүрдүүлэх, Үндэсний их баяр наадмыг зохион байгуулахтай холбоотой нарийвчилсан зохицуулалтыг бий болгосон гэх зэрэг олон асуудлыг зохицуулан холбогдох харилцааг зохицуулсан эрх зүйн орчныг боловсронгуй болгосон.

Гэвч Үндэсний их баяр наадмын тухай хуулийн зарим зохицуулалт нь бусад хуулийн зохицуулалттай зөрчилдөж, хуулийг нэг мөр хэрэглэхэд хүндрэлтэй байдлыг үүсгэж байна.

Тодруулбал, Үндэсний их баяр наадмын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.2-т "Хуульд өөрөөр заагаагүй бол Үндэсний их баяр наадмыг жил бүр Нийтээр тэмдэглэх баярын болон тэмдэглэлт өдрүүдийн тухай хуулийн 4.1.1-д заасны дагуу аймаг, сумын баяр наадмыг 07 дугаар сарын 10, 11-ний өдрүүдэд, улсын баяр наадмыг 07 дугаар сарын 11, 12, 13-ны өдрүүдэд улс орон даяар нэгэн зэрэг тэмдэглэнэ." гэж, Нийтээр тэмдэглэх баярын болон тэмдэглэлт өдрүүдийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1-д "Хуульд өөрөөр заагаагүй бол Үндэсний их баяр наадам, Ардын хувьсгалын ойн баяр: 7 дугаар сарын 10, 11, 12, 13, 14, 15;" гэж нийтээр тэмдэглэх буюу нийтээр амрах өдрүүдийг тус тус заасан болно. Өөрөөр хэлбэл, 7 дугаар сарын 10, 11, 12, 13, 14, 15-ны өдрүүд нь нийтээр тэмдэглэх баярын өдөрт хамаарах бөгөөд тухайн өдрүүдэд бүх нийтээр амрахаар заасан.

Харин Хөдөлмөрийн тухай хуулийн 97 дугаар зүйлийн 97.1.6-д "Үндэсний их баяр наадам, Ардын хувьсгалын ойн баяр: долдугаар сарын 11, 12, 13, 14, 15;" гэж заасан нь зөрчил үүсгэх бөгөөд хуулийг нэг мөр хэрэгжүүлэхэд хүндрэлтэй байдлыг бий болгож байна.

Тодруулбал, Нийтээр тэмдэглэх баярын болон тэмдэглэлт өдрүүдийн тухай хуулийн 4.1.1-д "Хуульд өөрөөр заагаагүй бол" гэсэн зохицуулалт нь Үндэсний их баяр наадмын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.2, 5.3 дахь хэсгийн "онцгой нөхцөл байдлаас" гэсэн нэр томъёотой холбоотой бөгөөд тухайн нөхцөл байдалд Үндэсний их баяр наадмын өдрүүдийг Нийтээр тэмдэглэх баярын болон тэмдэглэлт өдрүүдийн тухай хуулийн 4.1.1-д зааснаас өөр өдрүүдэд Засгийн газрын шийдвэрээр шилжүүлж болох зохицуулалттай болно.

Гэвч энэхүү зохицуулалтын "Хуульд өөрөөр заагаагүй бол" гэсэн нэр томъёо нь Хөдөлмөрийн тухай хуулийн 97 дугаар зүйлийн 97.1.6 дахь заалтад "Үндэсний их баяр наадам, Ардын хувьсгалын ойн баяр: долдугаар сарын 11, 12, 13, 14, 15;" гэж заасантай холбогдож, Хөдөлмөрийн тухай хуулийн 97 дугаар зүйлийн 97.1.6 дахь заалтыг баримтлахад хүрээд байна.

<sup>3</sup> Үндэсний их баяр наадмын тухай хууль "Төрийн мэдээлэл" эмхтгэлийн 2022 оны 25 дугаарт нийтлэгдсэн.

2. Үндэсний их баяр наадмын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.3 дахь хэсэгт Улсын баяр наадамд амжилт үзүүлсэн бөхөд цол олгох зохицуулалтыг заасан боловч зарим цол олгох зохицуулалтыг орхигдуулсан нь хуулийг хэрэглэхэд хүндрэлтэй байдлыг үүсгэхээр байна. Тухайлбал, Улсын арслан цолтой бөх өс даван түрүүлсэн тохиолдолд аварга цол олгох болон Улсын аварга цолтой бөх өс даван түрүүлбэл улсын даян аварга цол олгох зохицуулалт тус тус орхигдсон байна. Дээрх тохиолдолд цол олгохдоо Үндэсний их баяр наадмын тухай хуулийн ямар зохицуулалтыг үндэслэн цол олгох нь тодорхойгүй болох үр дагавартай болно.

3. Сүүлийн жилүүдэд улсын баяр наадамд түрүүлсэн, амжилттай сайн барилдаж цол, чимэг авсан бөх допинг хэрэглэсэн нь шинжилгээгээр тогтоогдож, цол, чимгээ хураалгах, хэрэглэсэн, хэрэглээгүй дээр маргалдах, шүүхээр шийдвэрлүүлэх тохиолдолд ихээхэн гарсаар байна. Үндэсний их баяр наадмын тухай хуульд допинг хэрэглэхийг хориглох, хэрэглэсэн тохиолдолд хүлээлгэх хариуцлагын механизмыг суулгаж өгсөн боловч энэ нь зөвхөн Улсын баяр наадамд дөрөв, түүнээс дээш давсан бөхөд хамааралтай байхаар заасан болно.

Харин аймгийн баяр наадам, түүнтэй адилтгах баяр наадам буюу алслагдсан дүүргийн баяр наадамд түрүүлсэн, шөвгөрсөн бөхөөс допингийн шинжилгээ авах зохицуулалт байхгүй байна. Аймгийн баяр наадам нь аймгийн цол авах, цаашлаад улсын цол авахад өндөр ач холбогдолтой баяр наадам юм.

4. Үндэсний их баяр наадмын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.5-д аймгийн баяр наадмын үндэсний бөхийн барилдаанд 128 бөх барилдахаар заасан нь тухайн аймгийн тэгш ойн баяр наадамд 128-аас дээш тооны бөх барилдах боломжийг тоогоор хязгаарлахаар байна.

Тухайлбал, бөх олонтой аймгийн тэгш ойн баяр наадамд Улсын аварга цолтноос эхлэн эрэмбэлэхэд аймгийн арслан цолтой бөхөөр бүртгэл хаагдаж, аймаг, сумын бусад цолтой бөх, залуу бөх бүртгүүлэх, барилдах нөхцөл хаагдахад хүрч байна.

5. Үндэсний их баяр наадам нь 1921-1925 оныг хүртэлх хугацаанд “Цэргийн наадам” гэж нэрлэгдэн цэргийн хүрээнд тэмдэглэж ирсэн бөгөөд 1925 оноос хойш “Үндэсний их баяр наадам”, “Улс хувьсгалын баяр наадам”, “Ардын хувьсгалын баяр наадам” зэргээр нэрлэгдэн Монгол Улс даяар тэмдэглэн ирсэн байдаг.

Түүнчлэн цэргийн “Хар сүлд” цэнгүүлэх ёслолыг хийж, баяр наадмыг зохион байгуулж ирсэн уламжлалтай. Бүх цэргийн наадамд 1961 оноос эхлэн түрүүлсэн бөхөд “Цэргийн арслан”, үзүүлэсэн бөхөд “Цэргийн заан” цолыг олгож ирсэн бөгөөд энэхүү цол олгох асуудал нь зохицуулалтгүй хэвээр байна. Тодруулбал, цэргийн баяр наадамд түрүүлсэн бөхөд “Цэргийн арслан” гэдэг цолыг аймгийн цолтой адилтган олгож байгаа боловч уг цолыг олгох зохицуулалт байхгүй, хууль зүйн хувьд үр дагавар үүсгэхгүй юм.

**Үндэсний их баяр наадмын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар:**

1. Хуулийн төслийн 1 дүгээр зүйлд нийт 2 хэсгийг тусгасан болно.

1.1. Хуулийн төслийн 1 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт Үндэсний их баяр наадмын тухай хуулийн 9 дүгээр зүйлд “9.3.6. улсын арслан цолтой бөх өс даван түрүүлбэл

улсын аварга, 9.3.6.улсын аварга цолтой бөх ес даван түрүүлбэл улсын даян аварга;" гэсэн 2 шинэ заалтыг нэмж байгаа болно.

Тодруулбал, Үндэсний их баяр наадмын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.3 дахь хэсэг нь Улсын баяр наадамд амжилттай барилдсан бөхөд олгох цолны шатлалыг 516 болон 1024 бөх барилдаж давсан, үзүүрлэсэн, түрүүлсэн тохиолдол тус бүрээр заасан болно. Тухайлбал, Үндэсний их баяр наадмын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.3.4-т найм давсан бөхөд улсын гарьд, 9.3.5-д ес давсан бөхөд улсын арслан, 9.3.6-д улсын арслан цолтой бөхөөс бага цолтой бөх 10 даван түрүүлсэн бол улсын аварга, 9.3.7-д ес даван түрүүлсэн улсын арслан цолтой бөх ес даван үзүүрлэсэн бол улсын аварга цолыг тус тус олгохоор заасан.

Харин дээрх зохицуулалтад улсын арслан цолтой болон улсын аварга цолтой бөх ес даван түрүүлсэн тохиолдолд ямар цол олгох нь тодорхойгүй байх тул уг тохиолдолд олгох цолыг хуульд нэмэхээр оруулсан болно.

Ингэхдээ бөхийн барилдааны тухайн даваа, цолны эрэмбийн дараалалтай уялдуулан улсын арслан цолтой бөх ес даван түрүүлсэн бол улсын аварга, улсын аварга цолтой бөх ес даван түрүүлсэн бол улсын даян аварга цол олгох зохицуулалтыг дээрх хуулийн 9.3.6, 9.3.7 дахь заалт болгон нэмж оруулсан.

Энэхүү зохицуулалтыг тусгасантай холбоотойгоор Үндэсний их баяр наадмын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.3.6, 9.3.7, 9.3.8, 9.3.9, 9.3.10, 9.3.11 гэсэн заалтын дугаарыг 9.3.8, 9.3.9, 9.3.10, 9.3.11, 9.3.12, 9.3.13 гэж өөрчлөх зохицуулалтыг Үндэсний их баяр наадмын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 4 дүгээр зүйлд тусгасан.

Үндэсний их баяр наадмын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 1 дүгээр зүйлийн 1-д тусгасан зохицуулалтыг Үндэсний их баяр наадмын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.3 дахь хэсэгт заасан "улсын арслан", "улсын аварга", "улсын даян аварга", "цол" гэсэн нэр томъёонд нийцүүлэн хэрэглэсэн тул нэр томъёоны хувьд дээрх хууль болон бусад хуультай зөрчил үүсэхгүй болно.

1.2.Хуулийн төслийн 1 дүгээр зүйлийн 3 дахь хэсэгт "9.9.Бүх цэргийн баяр наадмыг жилд нэг удаа Засгийн газрын шийдвэрээр 256 хүртэлх бөх барилдуулахаар зохион байгуулж болно. Бүх цэргийн баяр наадамд олгох цолыг аймгийн баяр наадамтай адилтган тав давсан бөхөд цэргийн начин, зургаа давсан бөхөд цэргийн харцага, үзүүрлэсэн бөхөд цэргийн заан, түрүүлсэн бөхөд цэргийн арслан цолыг батлан хамгаалах асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн олгоно." гэж тусгасан.

Үндэсний их баяр наадам нь 1921-1925 оныг хүртэлх хугацаанд "Цэргийн наадам" гэж нэрлэгдэн цэргийн хүрээнд тэмдэглэж ирсэн бөгөөд 1925 оноос хойш "Үндэсний их баяр наадам", "Улс хувьсгалын баяр наадам", "Ардын хувьсгалын баяр наадам" зэргээр нэрлэгдэн Монгол Улс даяар тэмдэглэн ирсэн байдаг.

Түүнчлэн цэргийн "Хар сүлд" цэнгүүлэх ёслолыг хийж, баяр наадмыг зохион байгуулж ирсэн уламжлалтай. Бүх цэргийн наадамд 1961 оноос эхлэн түрүүлсэн бөхөд "Цэргийн арслан", үзүүрлэсэн бөхөд "Цэргийн заан" цолыг олгож ирсэн бөгөөд энэхүү цол олгох асуудал нь зохицуулалтгүй хэвээр байна. Тодруулбал, цэргийн баяр наадамд түрүүлсэн бөхөд "Цэргийн арслан" гэдэг цолыг аймгийн цолтой



адилтган олгож байгаа боловч уг цолыг олгох зохицуулалт байхгүй, хууль зүйн хувьд үр дагавар үүсгэхгүй юм.

Иймд Үндэсний их баяр наадмын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд дээрх зохицуулалтыг тусгасан.

Ингэж тусгахдаа уг баяр наадмыг Үндэсний их баяр наадмын тухай хуульд заасны дагуу аймгийн баяр наадамтай адилтган үзэж, Засгийн газрын шийдвэрээр зохион байгуулах, барилдах бөхийн тоог 256 хүртэл байх, тав давсан бөхөд цэргийн начин, зургаа давсан бөхөд цэргийн харцага, үзүүрлэсэн бөхөд цэргийн заан, түрүүлсэн бөхөд цэргийн арслан цол олгох, уг цолыг батлан хамгаалах асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн олгохоор тодотгосон. Энэ нь Үндэсний их баяр наадмын тухай хуулийн зүйл, хэсэг, заалтын уялдаа холбоог хангах, түүнчлэн хуулийг хэрэглэхэд ойлгомжгүй байдал үүсгэхгүй байх ач холбогдолтой болно.

Түүнчлэн хуулийн төсөлд бүх цэргийн баяр наадмыг аймгийн баяр наадамтай адилтган цол олгохоор заасан бөгөөд барилдах бөхийн тооны хувьд аймгийн баяр наадамтай адил байхаар 128, 256 болгон хуулийг нэг мөр хэрэглэх үүднээс уг барилдаанд барилдах бөхийн тооны дээд хязгаарыг 256 гэж заасан болно.

Харин цолыг аймгийн баяр наадмын хувьд тухайн аймгийн Засаг дарга олгохоор зааснаас ялгаатай байдлаар Батлан хамгаалах тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.6-д "улсын хэмжээнд цэргийн спортын бодлогыг хэрэгжүүлж, хяналт тавих;" гэж заасантай уялдуулан тухайн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн олгохоор заасан болно.

Нэр томьёоны хувьд Батлан хамгаалах тухай хуульд заасан "цэргийн", Үндэсний их баяр наадмын тухай хуульд заасан "начин", "харцага", "заан", "арслан", цол гэсэн нэр томьёог хэрэглэн хуулийн төсөлд тусгасан тул шинээр нэр томьёоны тодорхойлолт, тайлбар хийх шаардлагагүй бөгөөд хууль хэрэглээнд хүндрэл гарахгүй болно.

1.3.Хуулийн төслийн 1 дүгээр зүйлийн 3 дахь хэсэгт "21.5.Аймгийн баяр наадам, түүнтэй адилтгах баяр наадмын бөхийн барилдаанд шөвгөрсөн бөхөөс допингийн шинжилгээг 2025 оны баяр наадмаас эхлэн авна." гэж тусгасан.

Үндэсний их баяр наадмын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2-т зааснаар Улсын баяр наадмын бөхийн барилдаанд дөрөв, түүнээс дээш давсан бөх, шөвгийн наймд шалгарсан эрэгтэй, эмэгтэй 8 сурын харваачаас допингийн шинжилгээг авахаар заасан болно.

Харин аймгийн баяр наадам болон түүнтэй адилтган үзэх алслагдсан дүүрэг, бүх цэргийн баяр наадмын бөхийн барилдаанд шөвгийн дөрөвт үлдсэн бөхөөс допингийн шинжилгээг авах зохицуулалт байхгүй болно. Эдгээр баяр наадамд түрүүлсэн, үзүүрлэсэн бөхөд аймаг, цэргийн цол олгож байгаа бөгөөд энэ нь бөхийн эрэмбийг тогтоох шалгуур үзүүлэлт болохоос гадна уг шинжилгээг авдаг болсноор тэгш, шударга өрсөлдөх спортын үндсэн зарчимтай нийцэх юм.

Иймд Үндэсний их баяр наадмын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2 дахь хэсэгт Улсын баяр наадамд дөрөв, түүнээс дээш давсан бөх, үндэсний сурын харвааны эрэгтэй болон эмэгтэй тус бүр эхний найман байр эзэлсэн харваачаас допингийн шинжилгээ авахаар заасныг өргөжүүлэн аймгийн баяр наадам, түүнтэй

адилтгах баяр наадамд шөвгийн дөрөвт үлдсэн бөхөөс тамирчны нэгэн адил допингийн шинжилгээг авах зохицуулалтыг хуулийн төслийн 2 дугаар зүйд тусгасан.

Энэхүү зохицуулалттай уялдуулан хуулийг хэрэгжүүлэх бэлтгэл ажлыг хангах, тухайлбал, хэрэгжүүлэхэд шаардлагатай төсвийг улсын төсөвт суулгах, допингийн шинжилгээг авах хүнийг сургаж, шинжилгээ авах журмыг боловсронгуй болгох зэрэг зохион байгуулалтын арга хэмжээ шаардлагатайг харгалзан аймгийн баяр наадам, түүнтэй адилтгах баяр наадмын үндэсний бөхийн барилдаанд шөвгөрсөн бөхөөс допингийн шинжилгээг авч эхлэх хугацааг 2 жилийн дараагаас буюу уг зохицуулалтыг 2025 оны баяр наадмаас хэрэгжиж эхлэхээр хуулийн төсөлд шилжилтийн үеийн зохицуулалтаар тусгасан.

Мөн энэхүү зохицуулалтын агуулгын хувьд аймгийн баяр наадам, түүнтэй адилтгах алслагдсан дүүрэг, бүх цэргийн баяр наадамд шөвгийн дөрөвт үлдсэн бөхөөс допингийн шинжилгээг авах хугацааг 2025 оны баяр наадам буюу Үндэсний их баяр наадмын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.2-т “Хуульд өөрөөр заагаагүй бол Үндэсний их баяр наадмыг жил бүр Нийтээр тэмдэглэх баярын болон тэмдэглэлт өдрүүдийн тухай хуулийн 4.1.1-д заасны дагуу аймаг, сумын баяр наадмыг 07 дугаар сарын 10, 11-ний өдрүүдэд, улсын баяр наадмыг 07 дугаар сарын 11, 12, 13-ны өдрүүдэд улс орон даяар нэгэн зэрэг тэмдэглэнэ.” гэж заасны дагуу уг баяр наадмаас эхлэн хэрэгжиж эхлэх юм.

Ингэхдээ Үндэсний их баяр наадмын тухай хуулийн 25 дугаар зүйлд шилжилтийн үеийн зохицуулалтыг заасан хэсэгт 25.5 гэсэн шинэ хэсгийг нэмэхээр хуулийн төсөлд тусгасан болно.

2.Үндэсний их баяр наадмын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 2 дугаар зүйлд Үндэсний их баяр наадмын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.5 дахь хэсгийн “аймгийн арслан цол олгоно.” гэсний дараа “Аймгийн тэгш ойн баяр наадамд 256 хүртэлх бөх барилдаж болно.” гэж, 14 дүгээр зүйлийн 14.2 дахь хэсгийн “дөрөв, түүнээс дээш давсан бөх,” гэсний дараа “9.5, 9.9-д заасан аймгийн баяр наадам, түүнтэй адилтгах баяр наадмын бөхийн барилдаанд шөвгийн дөрөвт үлдсэн бөх,” гэж тус тус тусгасан.

2.1.Үндэсний их баяр наадмын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.5-д аймгийн баяр наадмын үндэсний бөхийн барилдаанд 128 хүртэл бөх барилдахаар заасан нь тухайн аймгийн тэгш ойн баяр наадамд 128-аас дээш тооны бөх барилдах боломжийг тоогоор хязгаарлахаар заасан болно. Тухайлбал, бөх олонтой аймгийн тэгш ойн баяр наадамд Улсын аварга цолтноос эхлэн эрэмбэлэхэд аймгийн арслан цолтой бөхөөр бүртгэл хаагдаж, аймаг, сумын цолтой бөх, залуу бөх бүртгүүлэх барилдах нөхцөл хаагдахад хүрч байна. Иймд энэхүү тооны хязгаарлалтыг нэмэгдүүлэх хүрээнд хуулийн төслийн 2 дугаар зүйлд Үндэсний их баяр наадмын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.5 дахь хэсэгт “Аймгийн тэгш ойн баяр наадамд 256 хүртэлх тооны бөх барилдаж болно.” гэсэн агуулгыг нэмсэн.

2.2.Үндэсний их баяр наадмын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2 дахь хэсэгт Улсын баяр наадмын бөхийн барилдаанд дөрөв, түүнээс дээш давсан бөх, наймд шалгарсан эрэгтэй, эмэгтэй харваачаас допингийн шинжилгээг авахаар заасан болно. Харин аймгийн баяр наадам болон түүнтэй адилтган үзэх алслагдсан дүүрэг, цэргийн баяр наадмын шөвгөрсөн бөхөөс допингийн шинжилгээг авах зохицуулалт байхгүй бөгөөд баяр наадамд түрүүлсэн, үзүүрлэсэн бөхөд аймгийн

цол олгож байгаа бөгөөд энэ нь бөхийн эрэмбийг тогтоох шалгуур үзүүлэлт болох юм.

Тодруулбал, допингийн шинжилгээг улсын баяр наадмын үндэсний бөхийн барилдаанд дөрөв, түүнээс дээш давсан нийт бөх, аймаг, цэргийн баяр наадмын үндэсний бөхийн барилдаанд шөвгийн дөрөвт үлдсэн бөх, алслагдсан дүүргийн баяр наадмын үндэсний бөхийн барилдааны шөвгийн дөрөвт үлдсэн нийт бөх допингийн шинжилгээг өгөх зохицуулалттай болох юм.

Нэр томьёоны хувьд аймгийн баяр наадам гэдэг нь Үндэсний их баяр наадмын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1, 5.2-т заасан Нийтээр тэмдэглэх баярын болон тэмдэглэлт өдрүүдийн тухай хуулийн 4.1.1-д заасны дагуу аймаг, сумын баяр наадмыг 07 дугаар сарын 10, 11-ний өдрүүдэд зохион байгуулагдах Үндэсний их баяр наадмын бүрдэл хэсгийг ойлгоно.

Харин хуулийн төсөлд тусгасан аймгийн баяр наадамтай адилтгах баяр наадам гэдэгт Үндэсний их баяр наадмын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.7-д “Улсын баяр наадмаар нийслэлийн алслагдсан дүүргийн баяр наадмыг тусад нь зохион байгуулж болно.” гэж, 5.8-д “Энэ хуулийн 5.7-д заасан баяр наадмыг зохион байгуулахад аймгийн баяр наадамтай адилтган үзнэ.” гэж тус тус заасны дагуу “алслагдсан дүүргийн баяр наадам” болон 9 дүгээр зүйлийн 9.9-д заасан цэргийн баяр наадмыг ойлгоно. Тухайлбал, Улаанбаатар хотоос алслагдсан дүүрэгт Багануур, Багахангай, Налайх гэсэн 3 дүүргийг ойлгоно.

Үндэсний их баяр наадмын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.2-т Нийтээр тэмдэглэх баярын болон тэмдэглэлт өдрүүдийн тухай хуулийн 4.1.1-д заасны дагуу аймаг, сумын баяр наадмыг 07 дугаар сарын 10, 11-ний өдрүүдэд зохион байгуулахаар, 9 дүгээр зүйлийн 9.5-д “Аймгийн баяр наадамд 16 насанд хүрсэн 128 хүртэлх бөх барилдах бөгөөд тав давсан бөхөд аймгийн начин, үзүүрлэсэн бөхөд аймгийн заан, түрүүлсэн бөхөд аймгийн арслан цол олгохоор тус тус заасны дагуу аймаг, алслагдсан дүүрэг (Багануур, Багахангай, Налайх)-ийн баяр наадмыг 7 дугаар сарын сарын 10, 11-ний өдрүүдэд, 16 насанд хүрсэн 128 хүртэлх бөхийн барилдаан болох бөгөөд аймгийн цол олгоно.

3.Үндэсний их баяр наадмын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.8 дахь хэсгийг “9.8.Улсын баяр наадамд түрүүлж, үзүүрлэж, шөвгөрсөн бөхчүүдийн эрэмбийг Монголын үндэсний бөхийн холбооны дүрмээр зохицуулна.” гэж өөрчлөн найруулахаар Үндэсний их баяр наадмын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд тусгасан.

Монголын Үндэсний бөхийн холбоо нь үндэсний бөхийн мэргэжлийн холбоо бөгөөд одоогоор үндэсний бөхийн барилдаан зохион байгуулалт, эрэмбийг гаргах, бөхийн эрх ашгийг хамгаалах, допингийн шинжилгээг холбогдох байгууллагатай хамтран зохион байгуулах зэрэг үндэсний бөхийн барилдаантай холбоотой бүхий л чиг үүргийг хэрэгжүүлж байгаа нэг байгууллага юм.

4.Үндэсний их баяр наадмын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 4 дүгээр зүйлд Үндэсний их баяр наадмын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.3.6, 9.3.7, 9.3.8, 9.3.9, 9.3.10, 9.3.11 дэх заалтын дугаарыг “9.3.8, 9.3.9, 9.3.10, 9.3.11, 9.3.12, 9.3.13” гэж өөрчлөхөөр тусгасан.

Үндэсний их баяр наадмын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 1 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт бөхийн барилдааны тухайн даваа, цолны эрэмбийг дараалалтай уялдуулан улсын арслан цолтой болон улсын аварга цолтой бөх ес даван түрүүлсэн улсын арслан цолтой бөх ес даван түрүүлсэн болон улсын аварга, улсын аварга цолтой бөх ес даван түрүүлсэн бол улсын даян аварга цол олгох зохицуулалтыг дээрх хуулийн 9 дүгээр зүйлд 9.3.6, 9.3.7 заалт болгон оруулахаар тусгасан.

Энэхүү зохицуулалтыг тусгасантай холбоотойгоор Үндэсний их баяр наадмын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.3.6, 9.3.7, 9.3.8, 9.3.9, 9.3.10, 9.3.11 гэсэн заалтын дугаарыг “9.3.8, 9.3.9, 9.3.10, 9.3.11, 9.3.12, 9.3.13” гэж өөрчлөх зохицуулалтыг оруулсан болно.

5.Үндэсний их баяр наадмын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг 2023 оны 7 дугаар сарын 07-ны өдрөөс буюу Ардын хувьсгалын 102 жилийн ойн Үндэсний их баяр наадмаас өмнө дагаж мөрдөхөөр тусгасан болно.

**Хөдөлмөрийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн тухайд:**

Хөдөлмөрийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл нь 2 зүйлтэй бөгөөд Хөдөлмөрийн тухай хуулийн 97 дугаар зүйлийн 97.1.6 дахь заалтын “11,” гэснийг “10, 11,” гэж өөрчлөх, уг өөрчлөлтийн Үндэсний их баяр наадмын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт орсон өдрөөс эхлэн дагаж мөрдөхөөр тусгасан болно.

1.Үндэсний их баяр наадмын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.2-т “Хуульд өөрөөр заагаагүй бол Үндэсний их баяр наадмыг жил бүр Нийтээр тэмдэглэх баярын болон тэмдэглэлт өдрүүдийн тухай хуулийн 4.1.1-д заасны дагуу аймаг, сумын баяр наадмыг 07 дугаар сарын 10, 11-ний өдрүүдэд, улсын баяр наадмыг 07 дугаар сарын 11, 12, 13-ны өдрүүдэд улс орон даяар нэгэн зэрэг тэмдэглэнэ.” гэж, Нийтээр тэмдэглэх баярын болон тэмдэглэлт өдрүүдийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1-д “Хуульд өөрөөр заагаагүй бол Үндэсний их баяр наадам, Ардын хувьсгалын ойн баяр: 7 дугаар сарын 10, 11, 12, 13, 14, 15;” гэж нийтээр тэмдэглэх буюу нийтээр амрах өдрүүдийг тус тус заасан болно. Өөрөөр хэлбэл, 7 дугаар сарын 10, 11, 12, 13, 14, 15-ны өдрүүд нь нийтээр тэмдэглэх баярын өдөрт хамаарах бөгөөд тухайн өдрүүдэд бүх нийтээр амрахаар заасан.

Харин Хөдөлмөрийн тухай хуулийн 97 дугаар зүйлийн 97.1.6-д “Үндэсний их баяр наадам, Ардын хувьсгалын ойн баяр: долдугаар сарын 11, 12, 13, 14, 15;” гэж заасан нь зөрчил үүсгэх бөгөөд хуулийг нэг мөр хэрэгжүүлэхэд хүндрэлтэй байдлыг бий болгож байна.

Тодруулбал, Нийтээр тэмдэглэх баярын болон тэмдэглэлт өдрүүдийн тухай хуулийн 4.1.1-д “Хуульд өөрөөр заагаагүй бол” гэсэн зохицуулалт нь Үндэсний их баяр наадмын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.2, 5.3 дахь хэсгийн “онцгой нөхцөл байдлаас” гэсэн нэр томъёотой холбоотой бөгөөд тухайн нөхцөл байдалд Үндэсний их баяр наадмын өдрүүдийг Нийтээр тэмдэглэх баярын болон тэмдэглэлт өдрүүдийн тухай хуулийн 4.1.1-д зааснаас өөр өдрүүдэд Засгийн газрын шийдвэрээр шилжүүлж болох зохицуулалттай болно.

Гэвч энэхүү зохицуулалтын “Хуульд өөрөөр заагаагүй бол” гэсэн нэр томъёо нь Хөдөлмөрийн тухай хуулийн 97 дугаар зүйлийн 97.1.6 дахь заалтад “Үндэсний их баяр наадам, Ардын хувьсгалын ойн баяр: долдугаар сарын 11, 12, 13, 14, 15;” гэж заасантай холбогдож, Хөдөлмөрийн тухай хуулийн 97 дугаар зүйлийн 97.1.6 дахь заалтыг баримтлахад хүрээд байна.

Иймд Хөдөлмөрийн тухай хуулийн 97 дугаар зүйлийн 97.1.6 дахь заалтын “11,” гэснийг “10, 11,” гэж өөрчлөхөөр тусгасан бөгөөд ингэснээр Үндэсний их баяр наадмын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.2-т “Хуульд өөрөөр заагаагүй бол Үндэсний их баяр наадмыг жил бүр Нийтээр тэмдэглэх баярын болон тэмдэглэлт өдрүүдийн тухай хуулийн 4.1.1-д заасны дагуу аймаг, сумын баяр наадмыг 07 дугаар сарын 10, 11-ний өдрүүдэд, улсын баяр наадмыг 07 дугаар сарын 11, 12, 13-ны өдрүүдэд улс орон даяар нэгэн зэрэг тэмдэглэнэ.” гэж, Нийтээр тэмдэглэх баярын болон тэмдэглэлт өдрүүдийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1-д “Хуульд өөрөөр заагаагүй бол Үндэсний их баяр наадам, Ардын хувьсгалын ойн баяр: 7 дугаар сарын 10, 11, 12, 13, 14, 15;” гэж тус тус заасантай нийцэх бөгөөд хууль хэрэглээний хувьд ойлгомжгүй байдал арилах юм.

Түүнчлэн, Нийтээр тэмдэглэх баярын болон тэмдэглэлт өдрүүдийн тухай хуулийн 4.1.1-д “Хуульд өөрөөр заагаагүй бол” гэсэн зохицуулалтыг Үндэсний их баяр наадмын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.2, 5.3 дахь хэсгийн “онцгой нөхцөл байдлаас” гэсэн нэр томъёотой уялдуулан хэрэглэж, Үндэсний их баяр наадмын өдрүүдийг Нийтээр тэмдэглэх баярын болон тэмдэглэлт өдрүүдийн тухай хуулийн 4.1.1-д зааснаас өөр өдрүүдэд Засгийн газрын шийдвэрээр шилжүүлж болох зохицуулалтыг нэг мөр хэрэглэх боломжтой болох юм.

----o0o----

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2023 оны ... дугаар  
сарын ... -ны өдөр

Улаанбаатар  
хот

### ҮНДЭСНИЙ ИХ БАЯР НААДМЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.** Үндэсний их баяр наадмын тухай хуульд дараах агуулгатай хэсэг, заалт нэмсүгэй:

**1/9 дүгээр зүйлийн 9.3.6, 9.3.7 дахь заалт:**

“9.3.6.улсын арслан цолтой бөх ес даван түрүүлбэл улсын аварга;  
9.3.7.улсын аварга цолтой бөх ес даван түрүүлбэл улсын даян аварга;”

**2/9 дүгээр зүйлийн 9.9 дэх хэсэг:**

“9.9.Бүх цэргийн баяр наадмыг жилд нэг удаа Засгийн газрын шийдвэрээр 256 хүртэлх бөх барилдуулахаар зохион байгуулж болно. Бүх цэргийн баяр наадамд олгох цолыг аймгийн баяр наадамтай адилтган тав давсан бөхөд цэргийн начин, зургаа давсан бөхөд цэргийн харцага, үзүүрлэсэн бөхөд цэргийн заан, түрүүлсэн бөхөд цэргийн арслан цолыг батлан хамгаалах асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн олгоно.”

**3/21 дүгээр зүйлийн 21.5 дахь хэсэг:**

“21.5.Аймгийн баяр наадам, түүнтэй адилтгах баяр наадмын бөхийн барилдаанд шөвгийн дөрөвт үлдсэн бөхөөс допингийн шинжилгээг 2025 оны баяр наадмаас эхлэн авна.”

**2 дугаар зүйл.** Үндэсний их баяр наадмын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.5 дахь хэсгийн “аймгийн арслан цол олгоно.” гэсний дараа “Аймгийн тэгш ойн баяр наадамд 256 хүртэлх бөх барилдаж болно.” гэж, 14 дүгээр зүйлийн 14.2 дахь хэсгийн “дөрөв, түүнээс дээш давсан бөх,” гэсний дараа “9.5, 9.9-д заасан аймгийн баяр наадам, түүнтэй адилтгах баяр наадмын бөхийн барилдаанд шөвгийн дөрөвт үлдсэн бөх,” гэж тус тус нэмсүгэй.

**3 дугаар зүйл.** Үндэсний их баяр наадмын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.8 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

“9.8.Улсын баяр наадамд түрүүлж, үзүүрлэж, шөвгөрсөн бөхийн эрэмбийг Монголын үндэсний бөхийн холбооны дүрмээр зохицуулна.”

**4 дүгээр зүйл.** Үндэсний их баяр наадмын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.3.6, 9.3.7, 9.3.8, 9.3.9, 9.3.10, 9.3.11 дэх заалтын дугаарыг “9.3.8, 9.3.9, 9.3.10, 9.3.11, 9.3.12, 9.3.13” гэж өөрчилсүгэй.

**5 дугаар зүйл.**Энэ хуулийг 2023 оны 07 дугаар сарын 07-ны өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2023 оны ... дугаар  
сарын ... -ны өдөр

Улаанбаатар  
хот

**ХӨДӨЛМӨРИЙН ТУХАЙ ХУУЛЬД  
ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

**1 дүгээр зүйл.**Хөдөлмөрийн тухай хуулийн 97 дугаар зүйлийн 97.1.6 дахь заалтын "11," гэснийг "10, 11," гэж өөрчилсүгэй.

**2 дугаар зүйл.**Энэ хуулийг Үндэсний их баяр наадмын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг